



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/39

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун бүс нутагт хэрэгжүүлэх “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хөрөнгө оруулагч нартай хийсэн уулзалтын арга хэмжээний зардалд 976 500 төгрөг, аймгийн нөхцөл байдалтай танилцахаар ажилласан Монгол Улсын Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга хошууч генерал Т.Бадралаар ахлуулсан ажлын хэсгийн орон нутагт ажиллах үеийн уулзалтын арга хэмжээний зардалд 260 000 төгрөг, Засаг даргын өргөмжлөл, жуух бичиг, үнэмлэх хэвлэх бичиг хэргийн зардалд 258 500 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 1 495 000 төгрөг /Нэг сая дөрвөн зуун ерөн таван мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.00176 Zax A/39 Ch